

ХУУЛЬ БУСААР МОНГОЛ УЛСЫН ХИЛ НЭВТРЭХ /ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 79, ЭРҮҮГИЙН ШИНЭ ХУУЛИЙН 89 ДҮГЭЭР ЗҮЙЛ/, ЭД ЗҮЙЛИЙГ УЛСЫН ХИЛЭЭР ХУУЛЬ БУСААР НЭВТРҮҮЛЭХ /ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 172¹, ЭРҮҮГИЙН ШИНЭ ХУУЛИЙН 175 ДУГААР ЗҮЙЛ/ ГЭМТ ХЭРЭГТ ШҮҮХЭЭС ОНОГДУУЛЖ БАЙГАА ЯЛ ШИЙТГЭЛИЙН БАЙДЛЫГ 2002 ОНЫ БАЙДЛААР СУДАЛСАН ТУХАЙ ТОЙМ

2003 оны 05 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

Спирт, согтууруулах ундааг улсын хипээр хууль бусаар оруулж ирэх явдал буурахгүй байгаагаар барахгүй харин ч өсөх хандлага гарч байгаатай холбогдуулан Упсын Дээд шүүхээс энэ төрлийн хэрэг болон уг хэрэгт ял шийтгүүлэгчдэд оногдуулж байгаа ял шийтгэл, хураагдсан спирт, эд зүйлийг устгах, улсын орлого болгоход анхаарах асуудлуудын талаар тодорхой тойм. Зөвлөмжүүдийг гарган хүргүүлж байсан боловч шүүхээс хуульд заагдаагүй үндэслэлээр ялыг хөнгөрүүлдэг, тэнсдэг, хураагдсан эд зүйлийг буцаан олгодог ээрэг дутагдал арилахгүй байсаар байна.

2002 онд шүүхээр нийт 9183 эрүүгийн хэрэг таслан шийдвэрлэгдсэний 0,5 хувь буюу 50 хэрэг нь эд зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн гэмт хэрэг байв. Нийт 13007 хүн ял шийтгүүлсний 0,7 хувь буюу 92 хүн энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн байна. 1987 оны Эрүүгийн хуулийн 79 дүгээр зүйл, Эрүүгийн шинэ хуулийн 89 дүгээр зүйлд заасан эрүүгийн 10 хэрэгт 39 хүн ял шийтгуулсан нь нийт ял шийтгүүлэгсдийн 0,3 хувь болж байна.

Эд зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн /92 хүний/ 56,5 хувь буюу 52 хүнд торгуулийн ял, 41 хувь буюу 38 хүнд хорих ял оногдуулж таслан шийдвэрлэжээ. Хорих ял оногдуулсан 38 хүний 63,1 хувь буюу 24 хүний хорих ялыг биечпэн эдлүүлж, 23,6 хувь буюу 9 хүний хорих ялыг тэнсэж, 5 хүний ялыг өршөөлийн хуульд хамруулан шийдвэрлэжээ.

Судалгаанаас үзэхэд 2002 онд эд зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн гэмт хэргийг шүүх тус бүрээр нь авч үзвэл Говь-Алтай аймгийн шүүх эрүүгийн 3 хэрэгт 8 хүн, Дорнод аймгийн шүүх эрүүгийн 2 хэрэгт 7 хүн, Дорноговь аймгийн шүүх эрүүгийн 28 хэрэгт 39 хүн, Өмнөговь аймгийн шүүх эрүүгийн 7 хэрэгт 13 хүн, Нийслэлийн шүүх эрүүгийн 6 хэрэгт 14 хүн, Увс аймгийн шүүх эрүүгийн 3 хэрэгт 10 хүн, Ховд аймгийн шүүх эрүүгийн 1 хэрэгт 1 хүнд ял шийтгэл оногдуулсан байна.

Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтэрсэн гэмт хэрэгт Дорнод аймгийн шүүх эрүүгийн 9 хэрэгт 35 хүн, Өмнөговь аймгийн шүүх эрүүгийн нэг хэрэгт 1 хүнд ял шийтгэл оногдуулжээ.

Судалгаанаас харахад Говь-Алтай, Увс, Дорнод, Ховд аймаг хилийн боомтгүй газраар хууль бусаар улсын хил зөрчих, хятад, тува иргэдтэй урьдчилан үгсэн тохирч, эд зүйлийг хууль бусаар улсын хил нэвтрүүлж, чанар муутай спирт, тамхийг их хэмжээгээр оруулж ирэх, хил дамжин мал хулгайлах гэмт хэрэг гарсаар байна. Уг гэмт хэрэгт шийтгүүлэгчдэд хууль бусаар улсын хил нэвтрэхдээ хилийн харуулын албаны дарга, хил хамгаалж буй ажилтан зэрэг албаны хүмүүст хахууль, шан харамж өгч улсын хил нэвтрэх, хориглосон буюу хязгаарласан барааг их хэмжээгээр оруулж ирэх тохиолдол сүүлийн үед тарах болов.

Өмнөговь аймгийн шүүхээр энэ төрлийн хэрэгт ял шийтгүүлэгсдийн байдлаас үзэхэд хилийн боомт нээгдэх үеэр зохих зөвшөөрөлгүй буюу боловсруулаагүй ноолуур, арьс шир, эд зүйл алт, мөнгийг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлж, оронд нь хятад спирт оруулдаг ба спиртийг гаалийн мэдүүлэгг химийн бодис, эсвэл машины эд анги гэх мэтээр худал мэдүүлж оруулж ирэхийг завдах явдал нилээд тарсан байна.

Дорноговь аймгийн шүүхээр ял шийтгүүлэгсдийн дотор хууль бусаар улсын хилийг нэвтэрсэн гэмт хэрэгт ял шийтгүүлэгсэд байхгүй байгаа нь Замын-Үүд боомтоор зөвхөн галт тэрэг, зөвшөөрөлтэй машин орж, гардагтай холбоотой бөгөөд энэ боомтоор хил нэвтэрч байгаа хятад, монголын иргэд нь байгалийн түүхий алт, бугын чив, согооны суул, ангийн арьс, үсийг нууцаар улсын хил нэвтрүүлэх, хязгаарласан болон хориглосон бараа эсвэл хүнсний стандартын шаардлагад нийцээгүй архи, тамхи, спирт, өндөг зэрэг барааг улсын хил нэвтрүүлэхийг эвдсэн гэмт хэргүүдийг ихэвчлэн үйлдэж байна. Гэхдээ Замын-Үүд боомтоор эд зүйл хууль бусаар нэвтрүүлсэн хэрэгт шийтгүүлэгсэд нь голдуу тухайн хэргийг ганцаар үйлдэж байгаа бөгөөд оруулж ирж буй спирт, тамхины хэмжээ нь бусад аймгийн ял шийтгүүлэгсдийнхтэй харьцуулахад харьцангуй бага, барааг голдуу өөрийн бие болон авч яваа бараандаа нуух зэрэг аргыг ихэвчлэн хэрэглэж байна.

Харин Увс, Говь-Алтай аймагт эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх хэргийг бүлэглэн үйлдэж, спиртийг онц их хэмжээгээр оруулахдаа машин механизм бусад тээврийн хэрэгслэлийг ашиглаж байгаа нь судалгаагаар тогтоогдож байна.

Эдгээр хэрэгт ял шийтгүүлэгсдэд оногдуулсан ял харьцангуй хөнгөн гэж үзэхээр байна. Өмнөговь аймгийн шүүхийн 2002 оны 06 дугаар сарын 4- ний өдрийн 97 дугаар тогтоолоор шүүгдэгч Б.Санжаасүрэнд Эрүүгийн хуулийн 79 дүгээр зүйлийн 1, 172¹ дугаар зүйлийн 1-д зааснаар 10 сар хорих ял, Ю.Жаргалсайхан, Г.Занахүү нарт Эрүүгийн хуулийн 172¹ дугаар зүйлийн 1-д зааснаар тус бүрт нь 8 сарын хорих ял оногдуулж байсан байна. Эдгээр шүүгдэгч нар нь 2002 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр улсын хилээр 2 сая 100000 төгрөгийн үнэ бүхий 1050 л спиртийг нэвтрүүлсэн гэмт хэрэг үйлджээ. Гэтэл сарын дараа буюу 2002 оны 7 дугаар сарын 01-нд мөн аймгийн сум дундын шүүхийн 120 дугаар тогтоолоор 3 сая 800000 төгрөгийн үнэ бүхий 1900 л спиртийг улсын хилээр нэвтрүүлсэн хэрэг үйлдсэн шүүгдэгч Г.Нямсүрэнд 1 жилийн хорих ял оногдуулан уг ялыг тэнсэж 2 жилийн хугацаагаар хянан харгалзсан нь ойлгомжгүй байгаа бөгөөд тус шүүх энэ зохисгүй байдалдаа дүгнэлт хийхийг зориуд анхааруулж байна.

Мөн 2001 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 17,0 тн хятад спиртийг "ноос угаадаг химийн бодис" нэрээр ачиж Монгол Улсын хилээр оруулахыг завдсан Д.Ган-Эрдэнэд Говь-Алтай аймгийн сум дундын шүүхийн 2001 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 170 дугаар таслан шийдвэрлэх тогтоолоор 180000 төгрөгөөр торгох ял шийтгэснийг Улсын Дээд Шүүхийн Танхимын Тэргүүн шүүгчийн 2002 оны 230 дугаар эсэргүүцлийн дагуу хөнгөн ял оногдуулсан гэж үзэн дахин хэлэлцүүлэхээр мөн шүүхэд буцаажээ. Сум дундын шүүх уг хэргийг дахин хянан хэлэлцээд 2002 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 99 дүгээр таслан шийдвэрлэх тогтоолоор Д.Ган-Эрдэнэд 1 жилийн хорих ял оногдуулж, уг ялыг тэнсэж 2 жилийн хугацаагаар хянан харгалзсан байгаагаас үзэхэд түүнд оногдуулсан ял шийтгэл хэргийн бодит байдалд нийцээгүй, ял шийтгэлийн цээрлүүлэх ач холбогдлыг бууруулсан байна.

Ер нь Говь-Алтай, Увс аймагт спиртийг онц их хэмжээгээр, хууль бусаар улсын хил нэвтрүүлэх гэмт хэргийг зохион байгуулалттай, бүлэг этгээдүүд үйлдэж байгаа нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдож байхад дээрх аймгуудын шүүхээс тухайн хэрэгт оногдуулж буй ял шийтгэл хөнгөн байгаа бөгөөд Дорноговь аймгийн шүүхийн энэ төрлийн хэрэгт оногдуулж буй ялтай харьцуулахад илт хөнгөн байгаа нь улсын хэмжээнд энэ төрлийн хэрэг /спирт, хууль бусаар улсын хил нэвтрүүлсэн/-т оногдуулах ял шийтгэлийн бодлого алдагдахад хүргэж байгааг зориуд анхааруулж байна.

Харин хууль бусаар нэвтрүүлсэн спирт, согтууруулах ундааны зүйл, энэ гэмт хэргээс олсон ашиг, орлогыг хуульд заасны дагуу заавал хураах, түүнийг улсын орлогод оруулах асуудал шүүхүүдэд жигд хэрэгжиж байгааг тэмдэглэх нь зүйтэй гэж үзлээ.

Дээрхи зөрчлүүдийг үндэслэн нийт шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчдэд зөвлөмжлөх нь:

1. Архидан согтуурахтай тэмцэх тухай Монгол улсын хууль, Монгол Улсын Эрүүгийн шинэ хуулийн 161, 175 дугаар зүйлийн заалтуудыг ёсчлон хэрэгжүүлж, Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимаас 1999 онд гаргасан энэ төрлийн хэргийг таслан шийдвэрлэж

байгаа байдлыг судалсан тухай зөвлөмжийг цаашид шүүхийн практикт үргэлжлүүлэн баримтлаж ажиллах,

2. Энэ гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинжийг харгалзан уг гэмт хэргийг давтан болон бүлэглэж үйлдсэн зэрэг хүндрүүлэн үзэх нөхцөл байдал байгаа тохиолдол бүрт яп шиитгэлийг зөв сонгон оногдуулж, ялын бодлогыг зохих түвшинд байлгах нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдалд нөлөө үзүүлнэ гэдгийг нийт шүүх, шүүгчдэд анхааруулж байна.

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ
ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ